| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 119,742,170.00 | 132,132,146.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 69,758,570.00 | 104,335,146.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 49,983,600.00 | 27,797,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-119,742,170.00** | **-132,132,146.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 14 | **Бусад эх үүсвэр** | -78,182,000.00 | -70,685,000.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | -78,182,000.00 | -70,685,000.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-78,182,000.00** | **-70,685,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 89,519,731.48 | 154,792,503.60 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 86,720,363.94 | 176,240,095.42 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 176,240,095.42 | 331,032,599.02 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,715,012,100.00 | 2,482,335,049.53 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,382,497,000.00 | 2,307,314,903.53 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,359,454,700.00 | 2,284,272,603.53 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,538,552,600.00 | 1,538,424,884.82 |
| 210101 | Үндсэн цалин | 1,122,402,200.00 | 1,130,941,899.67 |
| 210102 | Нэмэгдэл | 296,207,400.00 | 297,635,172.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,066,000.00 | 4,689,840.00 |
| 210104 | Урамшуулал | 94,249,300.00 | 85,643,446.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,627,700.00 | 19,514,527.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 209,548,000.00 | 207,901,213.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 148,165,700.00 | 145,832,420.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,345,500.00 | 15,599,555.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,276,500.00 | 12,951,852.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,069,300.00 | 3,042,319.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30,691,000.00 | 30,475,065.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 348,746,400.00 | 300,932,346.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,475,100.00 | 14,162,462.85 |
| 210302 | Түлш, халаалт | 325,172,800.00 | 280,467,540.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,098,500.00 | 6,302,344.07 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 73,147,000.00 | 70,826,741.79 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,997,500.00 | 11,862,313.60 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 37,472,900.00 | 34,054,061.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,857,700.00 | 6,032,376.79 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,725,000.00 | 568,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 869,900.00 | 1,056,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,224,000.00 | 17,253,990.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 111,385,100.00 | 93,752,591.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 20,776,500.00 | 20,445,401.00 |
| 210502 | Хоол, хүнс | 85,342,400.00 | 68,040,990.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,266,200.00 | 5,266,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,011,800.00 | 13,272,904.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,104,000.00 | 575,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 472,700.00 | 309,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,435,100.00 | 12,387,604.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,533,500.00 | 7,924,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,533,500.00 | 7,924,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,056,900.00 | 15,874,332.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,263,300.00 | 12,248,978.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,967,800.00 | 1,959,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 539,100.00 | 534,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 295,700.00 | 194,994.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,600.00 | 88,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 203,400.00 | 182,750.00 |
| 210807 | Газрын төлбөр | 188,300.00 | 174,510.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 60,700.00 | 45,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 450,000.00 | 445,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 39,473,400.00 | 35,363,590.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,592,900.00 | 17,483,490.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,880,500.00 | 17,880,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,042,300.00 | 23,042,300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,042,300.00 | 23,042,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,882,300.00 | 21,882,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,160,000.00 | 1,160,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **156,594,100.00** | **104,335,146.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 156,594,100.00 | 104,335,146.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 156,594,100.00 | 104,335,146.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 175,921,000.00 | 70,685,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 175,921,000.00 | 70,685,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,570,790,700.00 | 2,536,805,278.53 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,554,492,200.00 | 1,537,518,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,554,492,200.00 | 1,537,518,400.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 878,602,400.00 | 882,214,021.53 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 760,461,200.00 | 765,044,333.53 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 118,141,200.00 | 117,169,688.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 27,696,100.00 | 23,452,210.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 27,696,100.00 | 23,452,210.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 110,000,000.00 | 93,620,647.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 110,000,000.00 | 93,620,647.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **233,450,362.00** |

| | | |
|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **233,450,362.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 114,184,077.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 15,217,725.00 |
| 210101 | Үндсэн цалин | 10,500,000.00 |
| 210104 | Урамшуулал | 4,717,725.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 759,675.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 759,675.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,218,545.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,022,080.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,741,175.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,702,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,752,790.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 72,812,725.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 63,387,775.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,424,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 916,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 916,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 108,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 108,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,223,342.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,223,342.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,927,365.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,035,155.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,892,210.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 77,745,740.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 34,694,040.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 43,051,700.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **41,520,545.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 41,520,545.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 233,450,362.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 233,450,362.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 225,604,618.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,345,744.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тэлмэн сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэлмэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн 1/75 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан төр засгийн бодлого үйл ажиллагаатай нийцсэн орон нутгийн онцлог нөөц чадавхыг бүрэн дайчилсан судалгаанд суурилсан эдийн засаг нийгмийн бодлогыг хэрэгжүүлж хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг хүн амд ил тод шуурхай хүртээмжтэй хүргэж улс аймгийн хэмжээнд тэргүүлэх түвшинд хүргэхэд оршино гэсэн зорилтын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх
- Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлэх
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэх
- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлэх
- Хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй сум болох
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах
- Нийгмийн амар тайван байдлыг хангах
- Эрсдэлгүй, өндөр ашиг шим бүхий хөдөө аж ахуйг хөгжүүлэх гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ын үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэлмэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны мөнгөн хөрөнгийн орлого 3,655.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 54.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 41.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

*Мөнгөн хөрөнгө*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 331.0 сая төгрөг болж өмнөх оноос 154.8 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 88.9 сая төгрөг нь СХС-ийн, 51.3 сая төгрөг нь ОНХС-ийн, 190.9 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

*Авлага*

Авлага дансны үлдэгдэл 197.2 сая төгрөг болж өмнөх оноос 63.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн төвд үүссэн авлагатай холбоотой байна.

/төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| ЗДТГ | 199,039.00 | 4,890.98 |
| ИТХ | 137,007.05 | 142,047.44 |
| ЭМТ | 1,170,600.00 | 67,208,810.28 |
| Соёлын төв | 33,450.00 | 33,450.00 |
| СХС | 131,807,162.00 | 114,167,506.00 |
| ОНХС | - | 16,000,000.00 |
| ДҮН | **133,347,258.05** | **197,556,704.70** |

Илрүүлэлт: *ТШЗ-ын аудитаар Эрүүл мэндийн төв үүссэн авлагыг Корона вирусээр хэвтэн эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний норматив төсөв өртгийн тооцоолол үндэслэлгүй байна гэж үзэн 32.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.*

*Бараа материал*

Бараа материалын үлдэгдэл 369.2 сая төгрөг болж өмнөх оноос 60.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь эрүүл мэндийн төвд ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

*Үндсэн хөрөнгө*

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3,034.6 сая төгрөг болж 86.2 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

*Богино хугацаат өр төлбөр*

Өглөг дансны үлдэгдэл 7.1 сая төгрөг болж өмнөх оноос 1.8 сая төгрөгөөр өссөн байна.

/төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| ЗДТГ | 149,840.00 | 2,479,600.00 |
| ИТХ | 1,086.00 | 3,100.00 |
| ЭМТ | 1,100,000.00 | - |
| Сургууль | - | 4,501,417.00 |
| ОНХС | 4,000,000.00 | 100,000.00 |
| **ДҮН** | **5,250,926** | **7,084,117** |

*Цэвэр хөрөнгө*

Цэвэр хөрөнгийн дүн 3,925.2 сая төгрөг болж 190.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 2,867.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт тодотгол хийж 152.3 сая төгрөгөөр бууруулж 2,715.0 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,715.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,382.5 сая төгрөгийг урсгал зардалд, 156.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 175.9 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,554.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 760.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 28,0 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 118.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 110.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 143.9 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,537.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 767.5 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 23.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 117.2 сая төгрөг, нийт 2,445.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 15.2 сая төгрөг дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 93.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 16.4 сая төгрөгөөр тасарсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүйтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,482.3 сая төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 2.5 сая төгрөгийг сумын төсөвт, 0.2 сая төгрөгийг улсын төсөвт, 14.3 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 225.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7.3 сая, нийт 233.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 192.0 сая зарцуулж, үлдэгдэл 41.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

## 3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 129 мэдээллээс 125 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тэлмэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

**3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 1 заалт зөвлөмж өгсөн.

**4.2.1 Залруулсан алдаа**

Аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй байна.

**4.2 .2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

**4.2.3 Албан шаардлага**

Албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

**4.2.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1 Хяналттай холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт:</u> Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй,*

*дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал Тэмцээн уралдаан зохион байгуулж зохион байгуулалтын болон шагналын зардал гаргасан, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, зардлыг зориулалт бус зарцуулж ажилчдад хувцас худалдан авч өгсөн зэрэг зөрчлүүд байна.*

*Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.13.7 "энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд", 8 дугаар зүйлийн 8.4 "Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:*

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ЗДТГ | 5 | 47.5 | 2 | 42.5 | | | | | 3 | 5.0 |
| 2 | Эрүүл мэндийн төв | 5 | 38.1 | 3 | 4.6 | 1 | 32.5 | 1 | 1.0 | | |
| 3 | Хүүхдийн цэцэрлэг | 2 | 1.6 | | | 1 | 0.3 | | | 1 | 1.2 |
| 4 | Соёлын төв | 1 | 1.6 | 1 | 1.6 | | | | | | |
| 5 | Ерөнхий боловсролын сургууль | 2 | 2.1 | | | 1 | 0.6 | | | 1 | 1.5 |
| 6 | Төвлөрүүлэн захирагч | 1 | 1.5 | | | | | | | 1 | 1.5 |
| **Дүн** | | **16** | **92.4** | **6** | **48.7** | **3** | **33.5** | **1** | **1.0** | **6** | **9.2** |

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР Б.ЖАЛБАА

**ХЯНАСАН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДАГВАСҮРЭН